



Хичээлийн сэдэв: БНМАУ-ын боловсрол, шинжлэх ухаан, соёлын хөгжил





Хичээлийн
хэрэгслээ
бэлтгээрэй.

Анхаарч
сонсоорой

Сурах
бичгийнхээ 54-
55-р хуудас

Дэвтэрт
тэмдэглэл
хөтлөөрэй.

Хичээллэх
орчноо
бүрдүүлээрэй.



Өмнөх хичээлээр : БНМАУ-ын улс төр, эдийн засаг, соёлд гарсан гарсан өөрчлөлт



Сэхээтний төөрөгдөл



Атрын аян




Соёлын довтолгоон




Хичээлийн зорилго




Тухайн үеийн боловсрол, шинжлэх ухаан, соёлын хөгжилтийг гол үйл явдлаар төлөөлүүлэн асуудал шийдвэрлэх арга зүйгээр судалж, тайлбарлах чадвараа хөгжүүлнэ.



Ач холбогдол



Баримт
нотолгоо



Шалтгаан, үр
дагавар






Боловсролын салбарын хөгжилт



Боловсролын салбарт ямар өөрчлөлтүүд хийгдэв.





БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ХӨГЖИЛ



Нэгдсэн Үндэстний
Боловсрол, Шинжлэх ухаан,
Соёлын Байгууллага



ЮНЕСКО-ийн
Монголын Үндэсний
Комисс

Бүх нийтийг бичиг үсэгтэй болгох хөдөлгөөн үр дүнгээ өгч, 1970 он гэхэд хүн амны 89.3 хувь нь бичиг үсэг тайлагджээ. Үүнийг ЮНЕСКО өндрөөр үнэлж Н. Крупскаягийн нэрэмжит олон улсын алтан медалиар манай улсыг шагнасан байна.

1963 оны байдлаар улс ардын аж ахуйн нийт ажиллагсдын дотор бүрэн бус ба бүрэн дунд боловсролтой хүмүүс дөнгөж 8 хувийг эзэлж байсан бол 1985 онд 55 хувь болж өсчээ.

1960 онд их дээд сургуулиудад 6900 оюутан суралцаж байсан бол 1985 онд 24600 болж өсчээ.





БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ХӨГЖИЛ



Хэнтий аймгийн Бэрхийн уурхайн цэцэрлэг. 1963-1964 он.



Д.Нонна. Монгол улсад сургуулийн өмнөх боловсрол хөгжиж ирсэн нь номоос





Шинжлэх ухаан, техникийн хөгжил

Шинжлэх ухааны салбарууд хэрхэн хөгжив



1961 онд Шинжлэх ухааны хүрээлэнг шинжлэх ухааны академи болгон өөрчлөн зохион байгуулж эрдэм шинжилгээний суурь судалгааны төв болгов. ШУА-д байгаль, нийгмийн суурь судалгааны ажлууд хийгдэж, манай зарим эрдэмтэд судлаачид шилдэг бүтээлээ туурвиж байлаа.



Малын үүлдэр угсааг сайжруулах, ашиг шимийг нь нэмэгдүүлэх, үр тариа, хүнсний ногооны ургацыг дээшлүүлэх, шинэ сорт бий болгох, Геологийн судалгааны үр дүнд эрдэс, түүхий эдийн нөөцийг нэмэгдүүлж, түлш эрчим хүч, уул уурхайн үйлдвэрийг хөгжүүлэхэд ихээхэн нөлөө үзүүлжээ.



Монголын эрдэмтэд сансар судлалын “Интеркосмос” программыг хэрэгжүүлэх ажилд гар бие оролцож, 1981 онд Монгол хүн сансарт нисэв.



1981 оны гуравдугаар сарын энэ өдөр Ж.Гүррагчаа, В.Жанибеков нар.

1981 оны 3 сарын 22-нд БНМАУ-ын сансрын нисгэгч Жүгдэрдэмидийн Гүррагчаа ЗХУ-ын сансрын нисэгч Владимир Жанибековын хамт Союз-39 хөлгөөр сансарт хөөрч Салют-6 сансрын станцтай холбогдож байжээ.

Яруу найрагч Д. Батсүрэн, хөгжмийн зохиолч Г. Дарамзагд нар Монголын сансрын нисэгчид өргөх дуу зохиож

Суунаг цэнхэр хөлгөө унаад
Монгол залуу сансрыг зорилоо
Суудал тухлаад тэртээх од руу
Монгол түмэн багтаад нислээ
Өнөөдөр монгол хүү
Анхлан сансарт дүүллээ
Өгөөмөр зөвлөлт найзтайгаа
Андын гараа барилаа хэмээн бахдан
дуулж байв.



Шинжлэх ухаан, техникийн хөгжил

Дараах баримтыг уншиж санал, сэтгэгдлээ илэрхийлээрэй.

- Хэнийг яагаад буруутгав.
- Буруутгасан үндэслэл нь хэр бодитой вэ?

... **Феодалын байлдан дагуулалт, хаад ноёдын хоорондын тэмцлийг**, хэт тоочин, түүхийг бүтээгч ард түмний роль, **ангийн тэмцлийг** үгүйсгэсэн байна... “БНМАУ-ын түүхийн дээж бичигт” **хятадын сурвалж бичгээс 120** гаруй ишлэл авсан атлаа марксизм-ленинизмыг үндэслэгчдийн зохиол бүтээлээс **нэг ч ишлэл** авч тусгаагүйн дээр ардын хувьсгалын түүхийн баримт бичиг, БНМАУ-ын түүхийн гурван боть зохиол зэрэг чухал сурвалж материалаас 20 гаруйхан ишлэл оруулсан нь эмхтгэгчид (Г. Сүхбаатар, Л. Жамсран) Хятадын дарлагч ангийн эрх ашгийг хамгаалсан хуучин сурвалж бичгийг түүхэн үнэ цэнтэй зүйл мэтээр товойлгосныг харуулж байна.

МАХН-ын Төв Хорооны Улс төрийн товчооны тогтоол (1980)

Ц. Дамдинсүрэн гуай 1967-1969 онд 50 мянган орос монгол толь бичгийг зохион хэвлүүлжээ. 1970 онд МАХН-ын Төв хороо уг толь бичгийн хавсралтын тухай хэлэлцэж **үндсэрхэг үзэл** бүхий баримт оруулсан. **В. Ленин, VIII Богд Жибзундамба** нарын **төрснийг нэг зиндаанд** дараалуулан бичих зэргээр ангич байр суурь, улс төрийн сонор сэрэмж алдлаа.




Шинжлэх ухаан, техникийн хөгжил



Г. Сүхбаатар нь 1960 аад оноос эхлэн монголын эртний түүхээр 20 гаруй жил дагнан ажиллахдаа хүннү, сяньби нар монгол угсаатан мөн болохыг нотлон бичсэн ганц сэдэвт “Сяньби” зохиолоо 1971 онд, “Монголчуудын эртний өвөг” зохиолоо 1980 онд туурвин тус тус хэвлэн нийтлүүлжээ.

“Эх түүхийн үнэнийг мэдсэнээр өнгөрсөн үеийн баатарлаг үйл, гайхамшигт бүтээл туурвилаар бахархахын зэрэгцээ эх орныхоо тусгаар тогтнолоос урвах явдлыг жигшин үзэж, түүхэн хөгжлийн нэн бартаатай замнал, сургамжийг танин мэдэж, ойлгох болно”

<http://undesten.mn/45836.html> Шийрээвдорж Насанбат



Зүүн гар талаас нэг дэх эгнээ: Г.Сүхбаатар, Э.Чимэдцэрэн, Н.Ишжамц, Хоёр дахь эгнээ: Ч.Жүздэр, П.Ядамсүрэн, Ц.Санжаасүрэн, Л.Жамсран.



УТГА ЗОХИОЛ, УРЛАГИЙН ХӨГЖИЛ

Утга зохиол урлагийн салбар хэрхэн өөрчлөгдөв.




Ц. Гайтавын “Хорин тавт”, М. Цэдэнжавын “Морин хуур”, Б. Явуухулан “Би хаана төрөв”, “Тэхийн зогсоол”, П. Бадарч “Есөн эрдэнийн орон”, Ш. Сүрэнжав “Ерөн баатрын дууль”, Б. Лхагвасүрэн “Боржигоны бор тал” зэрэг шүлэг найраглалууд гарчээ.



Д. Намдаг “Цаг төрийн үймээн”, Л. Түдэв “Уулын үер”, “Нүүдэл суудал”, Ч. Лодойдамба “Тунгалаг тамир”, С. Удвал “Их хувь заяа”, Ж. Пүрэв “Аянга” зэрэг романуудад зохиогдсон байна.



Туужийн төрөл С. Эрдэнийн “Малын хөлийн тоос”, “Хөх хулгана жил” Д. Мягмарын уянгын туужууд, жүжиг, кино зохиол хөгжихөд Д. Намдаг, Ч. Чимэд, Л. Ванган, Д. Мягмар нарын бүтээлүүд гол үүрэг гүйцэтгэж байв.






УТГА ЗОХИОЛ, УРЛАГИЙН ХӨГЖИЛ



1963 онд Улсын хөгжимт драмын театрыг Дуурь бүжгийн театр, Улсын драмын театр болгон бие даалган зохион байгуулсан.





УТГА ЗОХИОЛ, УРЛАГИЙН ХӨГЖИЛ



1960-д оноос хойш Монгол кино үйлдвэр жилд дунджаар уран сайхны бүрэн хэмжээний 7-8 кино, баримтат кино 100, түүний дотор кино мэдээ 24-г бүтээж байв. 1988 онд “Мандухай сэцэн хатан” дэлгэцний гарсан нь томоохон үйл явдал байлаа.



Зургийн урлаг нь хөрөг, монгол зураг, тосон зураг, зураасан зураг, зурагт хуудас, тайзны чимэглэл, хулдаасан ба чулуун бар зэрэг олон арга хэлбэртэй хөгжсөн байна. Уран барималчид хөшөө дурсгалын багана, цогцолбор бүтээж иржээ. Д. Чоймбол “Сүхбаатарын хөшөө”, “Зайсан толгой дахь Монгол зөвлөлтийн дайчдын хөшөө”



УТГА ЗОХИОЛ, УРЛАГИЙН ХӨГЖИЛ



Дараах баримтыг уншиж санал, сэтгэгдлээ илэрхийлээрэй.

... Сүүлийн 2-3 жилд манай зарим зураач үзэл сурталгүй бүтээл гаргах, хөрөнгөтний урлагийг хэлбэрдэх арга барилыг дуурайсан хийсвэр зураг зурсан нь уран бүтээлийн зарим ажилтан харш үзэл суртлын нөлөөнд ямар нэг хэмжээгээр автагдсаныг гэрчлэх баримт мөн


МАХН-ын Төв Хорооны Улс төрийн товчооны тогтоол (1969)

... АНУ Олимп 84 зохион байгуулах хорооны үйл ажиллагааг гартаа оруулж аваад Зөвлөлтийн эсрэг, социализмын эсрэг хэнээрхэл дэгдээж, зүсэн зүйлийн хэт харгис, алан хядагчдын бүлэглэл дээрэмчдийн хэрцгий бүдүүлэг дайралт, дайсагнасан ажиллагааг илэрхий өөгшүүлэн дэмжиж байна. ...БНМАУ-ын Үндэсний олимпийн хороо олимпийн тоглолтын талаар бий болсон нөхцөл байдлыг тал бүрээс судалж үзээд XXIII олимпийн тоглолтод Монголын тамирчид оролцох боломжгүй гэж үзэж байна.


Монголын Үндэсний Олимпийн Хорооны мэдээгдлээс 1984



Гэрийн даалгавар



- ❑ Та бүхэн дараах даалгавруудын хувилбараас сонгож гүйцэтгээрэй
 - Хичээлийн агуулгын хүрээнд оюуны зураглал хийх
 - 2-3 эх сурвалж, баримтыг сонгон авч түүнийгээ тайлбарлах
 - Аав, ээж, өвөө, эмээтэйгээ тухайн үеийн талаар ярилцаж тэмдэглэл бичээрэй.
 - Агуулгад холбогдох нэр томъёог тэмдэглэх
 - Бүтээлийг дүгнэх, ач холбогдлыг тодорхойлох
 - Баримтат кино үзэх, түүнийгээ шинжлэх



АНХААРАЛ ТАВЬСАНД
БАЯРЛАЛАА.